



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Axiom
Where science meets business

Хэрэглэгчийн сонголтод нөлөөлж буй
хүчин зүйлс, харилцаа холбооны
үйлчилгээний нээлттэй байдлын
түвшинг тодорхойлох судалгаа - 2023

Зөвхөн захиалагчийн хэрэгцээнд бэлтгэв.



ӨМНӨХ ҮГ

Аксиом Инк ХХК нь "Хэрэглэгчийн сонголтод нөлөөлж буй хүчин зүйлс, харилцаа холбооны үйлчилгээний нээлттэй байдлын түвшинг тодорхойлох судалгаа-2023"-г амжилттай хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааг явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн "Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

Судалгааны өгөгдөл цуглуулж, шинжилгээ хийх, дүгнэлт боловсруулахдаа "Аксиом Инк" ХХК-ийн судлаачид нь захиалагч байгууллагаас хараат бус, бие даасан байдлаар гүйцэтгэсэн болно. Тус судалгааны дизайн, өгөгдөл цуглуулга, өгөгдлийн шинжилгээ, тайлан боловсруулах үйл явц нь шинжлэх ухааны зарчимд суурилсан бөгөөд судалгааг явуулахдаа ESOMAR (Санаа бодол, зах зээлийн судалгааны европын нийгэмлэг)-ийн ёс зүйн дүрмийг баримталж ажилласан болохыг миний бие баталж байна.

Аксиом Инк ХХК-ийн
гүйцэтгэх захирал
Г.Нарантунгалаг

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН НЭР: ХЭРЭГЛЭГЧИЙН СОНГОЛТОД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2023

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

СУДАЛГАА ГҮЙЦЭТГЭГЧ



ИНТЕРАКТИВ ТАЙЛАН ПЛАТФОРМ



СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН КОДЕКС



СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь харилцаа холбооны үйлчилгээ хэрэглэгчид хэрхэн хүртээмжтэй хүрч, амьдралын хэрэгцээ шаардлагад хэрхэн нөлөөлж байгааг тогтоох, тухайн үйлчилгээг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан чөлөөтэй сонгож хэрэгцээгээ хангах боломж хэр нээлттэй, хүртээмжтэй байгааг тодорхойлох зорилготой.

СУДАЛГААНЫ ҮЙЛ ЯВЦЫН МЕНЕЖМЕНТ



Судалгааны
бэлтгэл
ажил
07/24-08/23



Судалгааны
өгөгдөл
цуглуулалт
08/24-09/06



Судалгааны
өгөгдлийн
шинжилгээ
09/07-09/15



Судалгааны
тайлан
боловсруулах
09/18-09/22



Судалгааны
тайлан
танилцуулах
09/25

Судалгааны асуулгын бүтэц:

- Хэрэглэгчдийн туршлага - 1 бүлэг асуулт, 4 багц үйлчилгээ
 - Хэрэглэгчдийн сэтгэл ханамж - 1 бүлэг асуулт, 4 багц үйлчилгээ
 - Хэрэглэгчийн шилжих зан төлөв - 2 асуулт
 - Шилжилт хийхэд тулгарч буй саад бэрхшээл, зардал - 2 асуулт
 - Радио FM-ын үйл ажиллагаа - 1 асуулт
 - Үйлчилгээний хүртээмжийг сайжруулахтай холбоотой нээлттэй 1 асуулт
- Нийт 4 бүлэг, 14 асуулттай фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулав.

Судалгааны загварыг турших:

2023/08/18 болон 2023/08/23-ны өдрүүдэд судалгааны асуулгын туршилтыг Аксиом инк ХХК-ийн ажилтнуудын дунд явуулан судалгааны асуулгатай холбоотой санал хүсэлт ирснийг хүлээн авч дахин хянаж, засварласан.

Судалгааны өгөгдөл цуглуулах:

Судалгаанд Улаанбаатар хотын болон 3 аймаг, 1 сумын иргэдээс нийт 79 оролцогчийг 11 бүлэгт хувааж, ярилцлагыг модератор хөтлөн явуулсан.

Судалгааны өгөгдлийн шинжилгээ:

Өгөгдлийн шинжилгээг 4 бүлэг, 8 багцын 14 асуултын хүрээнд агуулгын шинжилгээ хийж, дүгнэв.

Интерактив судалгааны тайлан:

Энэхүү судалгааны тайлан нь таныг хүснэгт, графикуудтай ажиллаж, хүссэн өгөгдлүүдэд харьцуулалтууд хийх, логик холбоостойгоор тайлантай танилцах боломжийг олгодог.



Хэрэглэгчийн сэтгэл ханамж
(Customer Satisfaction)




*Сэтгэл ханамж гэдэг нь тухайн бүтээгдэхүүн, байгууллагын талаарх өмнөх туршлага, хүлээлт хоёрын хоорондын зөрүүтэй байдал юм. Өөрөөр хэлбэл тухайн байгууллагатай харилцаж, бүтээгдэхүүн үйлчилгээг авсны дараа олж мэдсэн бодит гүйцэтгэл, өмнөх хүлээлт хоорондын зөрүүг үнэлэхэд үзүүлэх сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл юм.



Хэрэглэгчийн туршлага
(Customer Experience)



*Хэрэглэгчийн туршлага нь хэрэглэгчид аливаа үйлчилгээг хүлээн авах явцдаа харилцаж буй бүхий л туршлагыг хэлнэ. Энэ нь үйлчлүүлэгчийн байгууллагын талаарх хүртэхүйн нийлбэр байх ба харилцаа нь илүү сайн байх тусам туршлага нь илүү сайн байх болно.



Хэрэглэгчийн шилжих зан төлөв
(Customer Switching Behavior)



*Үйлчлүүлэгчийн шилжих зан төлөв нь хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэгчээ орхин өөр үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээг илүүд үзэх үед үүсдэг. Ингэснээр анхны үйлчилгээ үзүүлэгчийн хувьд ирээдүйн ашгаа алдаж, шинэ хэрэглэгчдийг олж авахад зардал гаргах нөхцөл бүрддэг.



1. Үйлчилгээний үнэ
2. Тав тухгүй байдал
3. Үйлчилгээний доголдол
4. Өрсөлдөгийн анхаарал татах байдал
5. Үйлчилгээ үзүүлэгчийн ёс зүйн асуудал
6. Сайн дурын бус шилжилт



Шилжилт хийхэд тулгарч буй саад бэрхшээл, зардал
(Customer Switching Barrier/Cost)



*Үйлчлүүлэгчийн шилжих зардал нь одоогийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаасаа татгалзаж шинэ үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгох болон түүнтэй харилцаа тогтоохтой холбогдон гарах зардал, саад бэрхшээлийн талаарх ойлголт юм.



1. Эдийн засгийн зардал
2. Хүчин чармайлтын зардал
3. Брэндийн зардал
4. Харилцааны зардал
5. Суралцах зардал

СУДАЛГААНЫ ДИЗАЙН

СУДАЛГААНЫ ДИЗАЙН



Хэрэглэгчийн шилжих зан төлөв (Customer Switching Behavior)



Үйлчилгээний үнэ(Pricing)

Үйлчилгээний үнэ хэмээх ангилалд үнэ, хувь хэмжээ, хураамж, нэмэлт хураамж, үйлчилгээний хураамж, торгууль, үнийн хэлэлцээр, хямдрал, үнийн урамшуулал зэрэгтэй холбоотойгоор үйлчлүүлэгч үйлчилгээ үзүүлэгчээ солих нөхцөл байдалд үүсдэг.



Тав тухгүй байдал (Inconvenience)

"Тав тухгүй байдал" ангилалд үйлчилгээ үзүүлэгчийн байршил, ажиллах цаг, авах гэж буй үйлчилгээг хүлээх хугацаа, цаг авахаар хүлээгдэж буй үйлчлүүлэгчид таагүй мэдрэмж төрүүлсэн зэрэг бүх чухал тохиолдлуудыг багтааж болно.



Үйлчилгээний доголдол (Service failure)

Үйлчилгээний үндсэн доголдолд техникийн асуудлаас үүдэлтэй бүх тохиолдлууд багтах ба харин харилцагчийн үйлчилгээний доголдолд үйлчлүүлэгчид болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд хоорондын харилцаанаас үүссэн үйлчилгээний доголдол гэж тодорхойлж болно



Өрсөлдөгчдийн анхаарал татах байдал (Competition)

"Өрсөлдөгчдийн анхаарал татах байдал" нь үйлчлүүлэгчид сэтгэл ханамжгүй үйлчилгээ үзүүлэгчээс илүү сайн үйлчилгээ үзүүлэгч рүү шилжих үед бий болох нөхцөл байдал бөгөөд үйлчлүүлэгчид илүү найрсаг, илүү найдвартай эсвэл илүү чанартай үйлчилгээ үзүүлдэг байгууллага рүү шилжсэн үеийн нөхцөл байдал юм.



Үйлчилгээ үзүүлэгчийн ёс зүйн асуудал (Ethical problems)

"Үйлчилгээ үзүүлэгчийн ёс зүйн асуудлууд" ангилалд хууль бус, ёс суртахуунгүй, аюултай, эрүүл бус эсвэл нийгмийн хэм хэмжээнээс ихээхэн гажсан болон бусад зан үйлийг бий болгосон тохиолдлууд багтдаг.



Сайн дурын бус шилжилт (Involuntarily switching)

Үүнд үйлчилгээ үзүүлэгч байгууллага нүүсэн эсвэл үйлчлүүлэгч өөрөө нүүсэн, мөн даатгалын компани эсвэл бусад гуравдагч этгээд үйлчилгээний нөхцлөө өөрчилсөн зэрэг шалтгаанаар зайлшгүй өөрчлөх нөхцөл байдал үүссэн үед бий болно.




Шилжилт хийхэд тулгарч буй саад бэрхшээл, зардал (Customer Switching Barrier/Cost)



Эдийн засгийн зардал(Economic cost)

Шинэ төхөөрөмж худалдан авах, хуучин төхөөрөмжийг зарах, гэрээ цуцлах, урт хугацааны хөнгөлөлт урамшууллаа алдах зэрэг багтана.



Цаг хугацаа, хүчин чармайлтын зардал(Time and Effort cost)

Бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцлийг судлах, гэрээ байгуулах үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг суурилуулах гэх мэт.



Брэндийн харилцааны зардал (Brand relationship cost)

Тухайн брэндийн дүр төрх, ойлголтыг алдах.



Харилцааны зардал (Relationship cost)

Шинэ байгууллагын ажилтнуудтай харилцах, харилцаа холбоо тасрах зардал.



Суралцах зардал (Learning cost)

Шинэ төхөөрөмж үйлчилгээний нөхцөл, хэрэглээ зэргийг суралцахтай холбоотой зардал.

СУДАЛГААНЫ АРГА ТЕХНИК



Уг судалгаанд чанарын судалгааны арга болох **фокус бүлгийн ярилцлагын** аргыг ашиглав.

Фокус бүлгийн ярилцлага гэдэг нь мэдээлэл цуглуулахын тулд тодорхой орчинд хэсэг бүлэг оролцогчидтой хийгддэг ярилцлага юм. Урьдчилан тодорхойлсон хүн ам зүйн шинж чанаруудын дагуу бүлгийг сонгодог бөгөөд асуултууд нь сонгогдсон сэдвийг гүнзгийрүүлэн тодорхойлоход зориулагдсан байдаг.

Уг судалгааны ярилцлагын асуултууд нь бүтэцлэгдсэн (structured) хэлбэрээр явагдсан ба 8 багц асуултаас бүрдсэн.

Ингэхдээ асуулт бүр дараах шинж чанарыг агуулсан болно. Үүнд:

- Хоёрдмол утгагүй, тодорхой нэг санаанд төвлөрсөн.
- Ялгаварлалгүй, төвийг сахисан шинжтэй.
- Тийм, үгүй гэсэн хариулт өгөх боломжгүй, тодорхой учир шалтгаан, санаа бодлыг дэлгэрүүлэн хариулахад тохиромжтой.
- Судлаачийн үзэл бодолд хөтлөгдөж гажуудаагүй.

Фокус бүлгийн судалгааны аргын онцлог:

- Чанарын судалгааны нэг төрөл.
- Бүлгийн динамик байдлын ажиглалт, тэдний асуултуудад өгсөн хариулт, бүтээгдэхүүн үйлчилгээ эсвэл маргаантай сэдвүүдийн талаарх нэгтгэсэн санаа бодлыг чиглүүлж чаддаг.
- Ихэвчлэн маркетинг, номын сан, нийгмийн шинжлэх ухаан, хэрэглэгчийн судалгааны чиглэлээр өргөн ашигладаг.
- Ганцаарчилсан ярилцлагаас илүү нарийн, хүмүүсийн санал хүсэлтийг чөлөөтэй авч болдог, туршилт эсвэл том хэмжээний судалгаанаас хялбар зохион байгуулагддаг.
- Баталгаажуулах судалгааны арга юм.



СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцогчдийн
байршил

Судалгаанд
оролцогчдын
тоо ▾

1.	Баянзүрх	17
2.	Завхан	11
3.	Архангай	9
4	З-Тосонцэнгэл	9

1 - 10 / 10 < >

Уг судалгааг орон нутагт (3 аймаг, 1 сум) болон Улаанбаатар хотод оршин суугаа харилцаа холбооны үйлчилгээ авч хэрэглэдэг 79 иргэдээс 11 удаагийн фокус бүлгийн ярилцлагыг зохион байгууллаа. Судалгаанд оролцох түүврийг бүрдүүлэхдээ 1 бүлэгт **нас, боловсролын түвшний** хувьд ойролцоо, бусад хүн ам зүйн хүчин зүйлсээр олон талт байдлыг хангасан байхаар бүрдүүлэв.


Нэг. Хэрэглэгчийн туршлагатай холбоотой хэсэг



Үүрэн телефон



"Та үүрэн холбооны эдгээр операторуудаас алийг нь ашигладаг вэ? Ямар үйлчилгээ авдаг вэ? Ямар багцийг ашиглаж байгаа вэ? Давхар хэрэглэдэг бол түүнийгээ хэлж болно. Хэдий хэмжээний яриа, мессеж, дата ашигладаг вэ?"



Хэрэглээний төлбөр

27,000₮ (оролцогчдын сарын дундаж төлбөр)

Улаанбаат...

29,210₮

Орон нутаг

24,267₮

Датаны хэрэглээ

17 гб (сард дунджаар)

Улаанбаат...

18.4 гб

Орон нутаг

16.1 гб

Үйлчлүүлэгчийн хэрэгцээ, зорилго

1. Үндсэн дугаар нь мобиком дээр байдаг. Мобикомоос дата авах гэхээр 2500, 5000 гээд урьдчилсан төлбөрт болохоор хэцүү санагдаад, Юнителээс дараа төлбөрт дугаар авсан. Дараа төлбөрт нь дата нь яваад л байдаг юм билээ. Дараа төлчихдөг учир амар санагдсан. Яг нь үндсэн дугаар Мобиком дээр, тэгээд Юнителээрээ дата авчихдаг. Датагаа байнга ашигладаггүй болохоор, мобиком 2 хоногийн дата гэхээр их хэцүү. Өдөртөө 1 дата ашиглачихаад, дараа өдөр нь ашигладаггүй болохоор Юнител нь амар санагддаг.
2. яриа хийдэг дугаар барьдаг
3. яриа түлхүү хэрэглээд датаа бага зэрэг хэрэгл смс бичихгүй
4. урамшуулал сайн үйчилгээ сайн багш багц ашиглаж байна.
5. сард 45 гб бусад сүлжээнд үнэгүй

Нэг. Хэрэглэгчийн туршлагатай холбоотой хэсэг



Үүрэн телефон /давхар хэрэглээ/



Судалгаанд оролцогчдын **43%** нь 2 буюу түүнээс дээш операторын үйлчилгээг давхар хэрэглэж байна. Хэрэглэгчид үүрэн холбооны байнга ашигладаг үйлчилгээний зэрэгцээ дараах операторуудын үйлчилгээг давхар ашигладаг байна. Давхар хэрэглээ бий болж буй шалтгааныг ангилж харуулав.



Мобиком 8



Скайтел 7



Ондо 9



Жи-Моба... 1



Юнител 14

Операторуудын нэр дээр даран оролцогчдын санал хүсэлттэй танилцана уу

ЯРИХ. 10

ДАТА. 21

ЯРИХ БОЛОН ДАТА 6

БУСАД 2

Санал хүсэлт ▾

1. Үндсэн дугаар нь мобиком дээр байдаг. Мобикомоос дата авах гэхээр 2500, 5000 гээд урьдчилсан төлбөрт болохоор хэцүү санагдаад, Юнителээс дараа төлбөрт дугаар авсан. Дараа төлбөрт нь дата нь яваад л байдаг юм билээ. Дараа төлчихдөг учир амар санагдсан. Яг нь үндсэн дугаар Мобиком дээр, тэгээд Юнителээрээ дата авчихдаг. Датагаа байнга ашигладаггүй болохоор, мобиком 2 хоногийн дата гэхээр их хэцүү. Өдөртөө 1 дата ашиглачихаад, дараа өдөр нь ашигладаггүй болохоор Юнител нь амар санагддаг.
2. аав ээжрүү үнэгүй учраас Скайтел Дата хэрэглээг хангадаг төлбөр
3. Яриа, датанд
4. Юнител Дараа төлбөрт Моби урьдчилсан төлбөрт янз бүрийн

1 - 34 / 34 < >

Хоёр буюу түүнээс дээш операторыг зэрэг хэрэглэж байгаа нь аль нэг операторын үйлчилгээ хэрэглэгчийн хэрэглээний шаардлагатай бүрэн дүүрэн тохирохгүй байгааг илтгэж байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь дата хэрэглээний зорилгоор давхар хэрэглээг сонгодог байна.


Мобикомыг давхар хэрэглэж буй шалтгаан нь яриа хийх бол бусад операторуудын хувьд дата хэрэглээний зорилго давамгайлж байна.

Суурин телефон



"Та ажил болон хувийн хэрэгцээндээ суурин утас хэрэглэдэг үү? Хэрэглэдэг бол ямар компанийн, ямар үйлчилгээ авдаг вэ? Хэдий хэмжээний төлбөр төлдөг вэ?"

Only гэсэн товч дээр даран суурин утасны хэрэглээний зорилгыг ангилсан байдлаар санал хүсэлттэй танилцана уу.



<input checked="" type="checkbox"/> Ангилал	Record Count
<input type="text" value="Type to search"/>	
<input checked="" type="checkbox"/> Гэр бүл	6
<input checked="" type="checkbox"/> Ажил	5
<input checked="" type="checkbox"/> Хэрэглэдэггүй	2
<input checked="" type="checkbox"/> Хүүхдүүд руу	2
<input checked="" type="checkbox"/> Бусад	1

Санал хүсэлт ▾

- ажил дээр 13 200 МЦХ ажлын хэрэгцээнд хэрэглэдэг
- Юнивишн. Гэхдээ огт бараг ярихгүй. Хүүхдийн утас холбогдохгүй бол л нэг залгаж магадгүй. Тэрнээс утсыг нь бол бараг ашиглахгүй. Гурвалсан үйлчилгээ заавал ав гээд өгчихсөн.
- Юнивишн хэрэглэдэг. Тэгээд утас нь дагаж ирээд угаасаа. Тэгээд бүр бараг л хэрэглэдэггүй. Утасныхаа аппаратыг гаргаад залгаад тавьчихаар нэг настай хүмүүс хааяа хэрэглээд байгаа юм шиг байгаа юм. Тэгээд салгаад авчихвал хэрэглэхгүй.
- Юнивишн багц дотор үнэгүй болохоор гэр зуур ашиглаж байгаа
- Хүүхдүүд руу
- Хэрэглэдэг. Манайх бол дээр үед 90-ээд онд л хэрэглэдэг байсан. Одоо ч


Судалгаанд оролцогчдын 20.3% нь суурин утастай. Түүнээс 68.8% нь Юнивишний гурвалсан үйлчилгээний хүрээн суурин утсыг ашигладаг байна.

Суурин утастай боловч 12.5% нь огт ашигладаггүй гэсэн хариулт өгчээ.

Суурин утасны хэрэглээний зорилгыг ажил, гэр бүл, хүүхэд болон бусад гэсэн ангилалаар харуулав.



Та суурин интернетийн хэрэглээгээ хэрхэн, яаж хангадаг вэ? Хэдэн төгрөгийн ямар багц авдаг вэ? Суурин интернетийн гол хэрэглээ юунд зарцуулагддаг вэ?"



Хэрэглээний төлбөр

48,350₮ (оролцогчдын сарын дундаж төлбөр)

Улаанбаат...

50,900₮

Орон нутаг

42,640₮

Судалгаанд оролцогчдын 58.8% буюу 44 оролцогч нь Юнивишн хэрэглэдэг байна.

13.8% нь суурин интернет ашигладаггүй байна.


Хариулт ▾

- чатлах, юм үзэх, гэрийн комоор fb youtube мэдээллийн сайтууд гэх мэт зорилгоор л хэрэглэж байна. Тоглоом бол тоглодоггүй.
- хүүхэдтэй холбогдох нийгмийн сүлжээнд холбогдох, ихэвчлэн интернетээр youtube үздэг
- хүүхдүүдийн хэрэглээнд эхнэр ажил хийхэд нийгмийн сүлжээнд холбогдох
- хичээл чөлөөт цагт зориулан гэр дундаа ашиглаад байдаг
- хамгийн бага багц гурвалсан үйлчилгээ интенэт тоглоом
- гэр интернет, ажил дээрээ бас адил хэрэглэдэг 30 гб хэрэглээнд өрхийг хангаад байдаг ажил дээр дуусдаг гэрт ойр зурын хэрэглээнд ашиглаад байдаг хичээл ном ажил ер нь унтхаас бусад цагт ер нь ордог
- гэр интернет хэрэглэдэг дата 100гб гэртээ утсаар хэрэглэдэг зурагттай холбож юм үздэг ажил хийдэг



Та суурин интернетийн хэрэглээгээ хэрхэн, яаж хангадаг вэ? Хэдэн төгрөгийн ямар багц авдаг вэ? Суурин интернетийн гол хэрэглээ юунд зарцуулагддаг вэ?"

Судалгаанд оролцсон 79 оролцогчдоос нийтдээ 101 хэрэглээ байгаагаас Сошиал, Youtube, Ажлийн хэрэгцээнд, хэрэглээнүүд бусадтай харьцуулахад олон давтагдсан байна.




Үйлчлүүлэгч байгууллага

Хариулт

1. Facebook, Instagram, Youtube, хичээлээ хийхээр бол хичээлээ үзэх зэрэг ашигладаг.
2. Компьютер дээр тоглох зэргээр л хийдэг. Үнэ хэд байдгийг мэдэхгүй Сошиал ухах, зурагтан дээрээ Netflix үздэг.
3. null
4. null
5. Юнивишн 3лсан үйлчилгээ хэрэглээ сошил судалгаа сургууль хичээлд видео тоглоом



Та телевизийн олон сувгийн үйлчилгээг ямар компаниас авдаг вэ? Ямар хэрэгцээ шаардлагын үүднээс ашигладаг вэ? Дунджаар хэдэн төгрөгийн төлбөр төлдөг вэ?"



Хэрэглээний төлбөр

35,950₮ (оролцогчдын сарын дундаж төлбөр)

Улаанбаат...

42,500₮

Орон нутаг

24,400₮

Судалгаанд оролцогчдын 60.8% буюу 48 оролцогч нь Юнивишнээс олон сувгийн үйлчилгээг авдаг бол 27,8% нь ДДэш хэрэглэдэг байна.

3.8% нь олон сувгийн үйлчилгээ ашигладаггүй байна.

Хариулт ▾


- өөрийн сувгууд үздэг ихэвчлэн кино үздэг сарын төлбөрийг эгч авч өгдөг
- Үндэснийхээ телевизийг үзнэ. Мэдээ, танин мэдэхүйн нэвтрүүлэг бас их үздэг. Хүүхдүүд кино сувгуудаа их үздэг.
- энгийн дараа тв кино багц үнэгүй болгоод кино үздэг
- энгийн багц үздэг тв үзэхэд тохиромжтой
- хүүхдүүд л үздэг
- тв үзнээ сайн үздэг
- тв үздэггүй хүүдүүд үздэг
- тв үздэг

Олон сувгийн үйлчилгээ



Та телевизийн олон сувгийн үйлчилгээг ямар компаниас авдаг вэ? Ямар хэрэгцээ шаардлагын үүднээс ашигладаг вэ? Дунджаар хэдэн төгрөгийн төлбөр төлдөг вэ?"

Судалгаанд оролцсон 79 оролцогчдоос нийтдээ 106 хэрэглээ байгаагаас Кино үзэх, Гэр бүлийн хүүхдүүд зурагт үзэх, Нөхөж үзэх, Мэдээ үзэх, Нэвтрүүлэг үзэх зэрэг хэрэглээнүүд бусадтай харьцуулахад олон давтагдсан байна.



Only гэсэн товч дээр даран суурин утасны хэрэглээний зорилгыг ангилсан байдлаар санал хүсэлттэй танилцана уу.

Үйлчлүүлэгч байгууллага

Хариулт

1. Аав, ээж мэдээ үзэх гэж үздэг би өөрөө л үздэггүй.
2. *
3. Зурагт ерөөсөө үздэггүй.
4. ДДэштв Хүүхдүүдийн хэрэгцээнд үздэг
5. ДДэш 15 бараг асаадаггүй ер нь утас үзээд байж байдаг хаагдахаар болохгүй байхгүй болхоор болохгүй

Олон сувгийн үйлчилгээ /давхар хэрэглээ/



Та телевизийн олон сувгийн үйлчилгээг ямар компаниас авдаг вэ? Ямар хэрэгцээ шаардлагын үүднээс ашигладаг вэ? Дунджаар хэдэн төгрөгийн төлбөр төлдөг вэ?"



Сансар

Зөвхөн-Гэр бүл



VOO

Мэдээ 25

Кино



Look tv

Спорт суваг

Мэдээ

Хэрэгтэй тохиолдолд төлбөр төлөөд үздэг



MNBC

Гэр бүл-хүүхдүүд

Нэвтрүүлэг



Playmo

null



Ддэш

Гэр бүл-кино

Only гэсэн товч дээр даран суурин утасны хэрэглээний зорилгыг ангилсан байдлаар санал хүсэлттэй танилцана уу.

Давхар хэрэглээ

Хариулт

1. өөрийн сувгууд үздэг ихэвчлэн кино үздэг сарын төлбөрийг эгч авч өгдөг
2. Зурагт ерөөсөө үздэггүй.
3. Аав ээж мэдээлэл авдаг. Хааяа кино үздэг. Look tv ашигладаг.
4. Юнивишн, Look tv үздэг.
5. Телевиз гэвэл МҮОНРТ-ыг бараг үздэггүй, 25-р суваг гэх мэт ер мэдээний сувгууд, мэдээ л их үздэг. Спортын сувгийг бол байнга үздэг, хэдэн ч суваг байдаг юм бүү

Хоёр. Хэрэглэгчийн сэтгэл ханамжтай холбоотой хэсэг



Үүрэн телефон



"Өөрийн ашигладаг үүрэн холбооны операторын үйлчилгээний сэтгэл ханамжийг 1-10 хооронд үнэлнэ үү. Яагаад? Сэтгэл ханамжид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дурдана уу?"




Сэтгэл ханамж гэдэг нь тухайн бүтээгдэхүүн, байгууллагын талаарх өмнөх туршлага, хүлээлт хоёрын хоорондын зөрүүтэй байдал болон тухайн байгууллагатай харилцаж, бүтээгдэхүүнийг хэрэглэсний дараа олж мэдсэн бодит гүйцэтгэлийн хоорондын зөрүүг үнэлэхэд үзүүлэх сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл.

ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ

76%

ЭЕРЭГ



Санал хүсэлт ▾

1. үнэгүй байсан юмаа нэмээд үнэтэй болгоод байгаа Моби дата хурдан дуусдаг
2. Үнийн хувьд 500₮ нэмэгдсэн тул нэг оноо хасч байна.
3. Үлдсэн 1 хувь нь яасан бэ гэхээр, хааяадаа сонин сонин болчихдог үе байдаг. Сүлжээ унадаг ч юм уу. Ер нь л тэр л байгаалдаа. Нам дор газар, эсвэл хэт уулын гүн рүү орсон үед сүлжээ унадаг. Тэр нь л жаахан тиймэрхүү байдаг.
4. шалтгаан байхгүй 10 оноо өгөхгүй энэ тэнд сүлжээ унаад байдаг
5. сүүлийн 3 жил их гацалт үүсээд байдаг болсон.
6. датаа их ашиглаад байггүй нэгж аваад сонгоод хэргэлээд явахад хурдан дуусаад байдаг.
7. дата хангалттай бус уртаар богиноор ихээр багаар авч үзсэн хангалтгүй ярих дажгүй
8. дата удаан болсон гацалттай дата бас хурдан дуусдаг
9. дата удаан болсон гацалттай багш багцад ороод тийм болсон.
- 1... дата сардаа хүрдэггүй
- 1... аймгаас холдоод гарах юм бол сүлжээ муутай 8 оноо өгнө.

Хоёр. Хэрэглэгчийн сэтгэл ханамжтай холбоотой хэсэг





Үүрэн телефон



"Өөрийн ашигладаг үүрэн холбооны операторын үйлчилгээний сэтгэл ханамжийг 1-10 хооронд үнэлнэ үү. Яагаад? Сэтгэл ханамжид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дурдана уу?"

СӨРӨГ



Санал хүсэлт ▾

1. үнэгүй байсан юмаа нэмээд үнэтэй болгоод байгаа Моби дата хурдан дуусдаг
2. Үнийн хувьд 500₮ нэмэгдсэн тул нэг оноо хасч байна.
3. Үлдсэн 1 хувь нь яасан бэ гэхээр, хааяа сонин сонин болчихдог үе байдаг. Сүлжээ унадаг ч юм уу. Ер нь л тэр л байгаалдаа. Нам дор газар, эсвэл хэт уулын гүн рүү орсон үед сүлжээ унадаг. Тэр нь л жаахан тиймэрхүү байдаг.
4. шалтгаан байхгүй 10 оноо өгөхгүй энэ тэнд сүлжээ унаад байдаг
5. сүүлийн 3 жил их гацалт үүсээд байдаг болсон.
6. датаа их ашиглаад байггүй нэгж аваад сонгоод хэргэлээд явахад хурдан дуусаад байдаг.
7. дата хангалттай бус уртаар богиноор ихээр багаар авч үзсэн хангалтгүй ярих дажгүй
8. дата удаан болсон гацалттай дата бас хурдан дуусдаг
9. дата удаан болсон гацалттай багш багцад ороод тийм болсон.
10. дата сардаа хүрдэггүй
11. аймгаас холдоод гарах юм бол сүлжээ муутай 8 оноо өгнө.
12. Яагаад тэгж байна вэ гэхээр, зарим нэг үйлчилгээ нь заавал та манай салбар дээр ир гээд байдаг. Тэгээд

Суурин телефон



" Өөрийн ашигладаг суурин телефоны үйлчилгээний сэтгэл ханамжийг 1-10 хооронд үнэлнэ үү. Яагаад? Сэтгэл ханамжид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дурдана уу? "

Эерэг

Эерэг ▾

1. Яриа сайн
2. Хүссэн цагтаа хүн байгаа үед хүүхдүүдтэйгээ чөлөөтэй холбогдож чаддаг байсан.
3. Надад бол таалагдсан. Ер нь дажгүй
4. Миний хувьд цахилгаан холбоо боломжийн юм шиг санагддаг
5. Миний хувьд univision хэрэглэдэг. Хэрэгтэй үед ашиглая гэхээр байж байдаг. Асуудалгүй байдаг. 8 гэнэ.
6. Манайх univision-ы гурвалсан үйлчилгээг хэрэглэдэг. Ер нь бол адилхан. Хэрэглэе гэсэн үед байж байдаг. 9 гэж үнэлэнэ. Давуу тал нь бусад univision-ы суйран утасруугаа үнэгүй яридаг.

Сөрөг

Сөрөг ▾

1. хэрэглээ хангалттай хэдий ч заримдаа төлбөр төлчөөд байхад гарах яриа хязгаарлаад байдаг 20 мянгийн багц авдаг 100 минут хэдий ч дуусхаараа хаагдаад байдаг
2. Сул тал гэвэл төлбөрийн асуудал гардаг байсан. Төлчихөөд байхад ерөөсөө төлбөр нь ордоггүй. Ажлын утас болохоор. Заавал 2 3 яриулж байж л хийдэг байсан. Бусдаар асуудалгүй.
3. Дутагдалтай талыг сайн мэдэхгүй байна.

ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 87.7%

"Өөрийн ашигладаг суурин интернэтийн үйлчилгээний сэтгэл ханамжийг 1-10 хооронд үнэлнэ үү. Яагаад? Сэтгэл ханамжид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дурдана уу?"

Эерэгээр нөлөөлж буй хүчин зүйлс

ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ **80.3%**


21

Хангалттай

Хэрэглээнд хангалттай
Ерөнхийдөө гайгүй
Хэрэгцээг бүрэн хангадаг

6


Бусад



Үйлчилгээ сайтай
Тогтмол сайжирдаг

6

Асуудалгүй



Хэрэгцээнд нийцдэг

3

Гацдаггүй



2

Үнэ



Уян хатан
Хямд

2

Хурд



Тайлбар(Эерэгээр нөлөөлж буй хүчин зүйлс) ▾


1. Үзье гэсэн юмнуудаа хангалттай үзчихдэг болохоор.
2. хэрэгцээ хангаад байнга хэрэглэдэг
3. хэрэгцээ хангаад байдаг
4. уян хатан хямдхан
5. төлбөр өсөөд уян хатан болоод байгаа өсөөд л байна
6. миний хувьд бол Кевико Юнивишн 2-т 9-г өгнө. Гайгүй байдаг. Мобинет-г бодвол арай дээр санагддаг.
7. интернэт боломжийн 300гб дата хангалттай байдаг хэрэглээ сайн
8. гэр интернэт 100гб хүрдэггүй гэхдээ хангалттай сайн
9. гайгүй хурд хэрэглээ сайн.
10. гайгүй бүх ажил амжуулж байгаа гацалт энэ тэр гайгүй
11. Ямар ч асуудал гардаггүй.
12. Яагаад гэвэл тасалдал байдаггүй, удаан бол биш. Үнэ дээр бол сэтгэл ханамжгүй бол биш.
13. Юнивишнд бол яахав 8г өгнө. Арай хямдавтар VOO эд нар луу орчихдог юмуу гэхээр НВО эд нар байдаггүй болохоор шилжиж чадахгүй. Үйлчилгээний хувьд надад бол гайгүй санагддаг. Цагаан төхөөрөмж солих чинь бараг шуудангаар шууд явуулаад л заавраар нь хийчихэд хурдан асуудал нь шийдэгдчихдэг.
14. Юнивишнгийн операторуудтай нь харилцахаар IPTV нь гацчихдаг байхгүй юу Юнивишн чинь. Тэгээд л за ингээд бүх аргыг нь хэрэглээд л нөгөө гацаа нь гарахгүй байдаг байхгүй

1 - 39 / 39 < >

"Өөрийн ашигладаг суурин интернэтийн үйлчилгээний сэтгэл ханамжийг 1-10 хооронд үнэлнэ үү. Яагаад? Сэтгэл ханамжид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дурдана уу?"

Сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс


ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 80.3%



14

ХУРД SLOW DOWNLOAD


Нөгөө өрөөнд удаан ордог
Хажуу тийшээ харж хэвтэх үед муу ордог



11

СҮЛЖЭЭНИЙ ДОГОЛДОЛ


Орж гардаг
Асаагаад 10-15 минут хүлээдэг
Бороо салхитай үед



ҮЙЛЧИЛГЭЭ

Оператор утсаа авдаггүй
Асуудал шийдвэрлэхдээ удаан
Мэдлэг шаарддаг
Улам төвөгтэй болоод байгаа
Багц хүсээгүй авдаг


11



8

PRINCE ҮНЭ

Олон багц авах тусам үнэ нэмэгддэг
Нэмэлт төхөөрөмж



ТӨХӨӨРӨМЖ

Шинэ төхөөрөмж
Ойлгомжгүй

4

БУСАД

4

Тайлбар(Сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс) ▾	
1.	Өчигдөр тог тасраад буцаад ирсэн чинь орохгүй байсан байгаа харагдаад байгаа ч No internet connection гээд оройжин тийм байсан өглөө сэрээд босоод ирсэн зүгээр болчихсон байсан юм татахад бас аймар удаан татах үед хамгийн ихдээ 4мб/с байдаг тэр нь аймар удаан нэг юм татах гэж хэдэн цаг болно
2.	хэрэгцээ хангаад байдаг хэдий ч хааяа лавлахруу залгаад холбогдхоор их хүндрэлтэй сая сүлжээ саатах үед цахилгааны асуудал байсан гэтэл холбогдох үед эрчим тэйгээ холбогд гэсэн хариу өгсөн орцны буюу дамжуулах сүлжээнд саатал гарсан асуудал байсан тэхээр энэ тал дээр ойлгомжгүй байдал үүсгээд байгаа
3.	хурд нь сайн биш болсон гацаад байдаг
4.	хол өрөөнд орохоор ордоггүй. Тийм учраас датагаа асааж, hotspot цацдаг. Яг голлуулаад байрлуулсан тэр хавьдаа асуудалгүй ажилдаг. Өрөөнөөсөө бас орчихмоор л байна. төхөөрөмжөө солих шаардлагатай гээд дуудлага өгөөд бараг сар залгуулж байж ирж өгсөн. Тийм ганц сөрөг туршлагатай.
5.	төхөөрөмж солих нь асуудалтай
6.	төлбөрийн асуудал их гаргаад байдаг ойлгомжгүй, асах гэж уддаг
7.	төлбөр өндөр төлбөртэй
8.	нөгөө өрөөнүүдэд интернэт удаан ордог
9.	Яахав интернэт тасрах массын юм бол байдаг. Гэхдээ би юнивишний сүлжээг гайхаад байдаг юм нь, манайх 2 давхар байхгүй юу. Би 2 давхартаа байж байгаад, байшингийнхаа булан руу оччихоор сүлжээ нь уначихдаг. Наашаа 1 алхаад ирэхээд зүгээр болчихдог. Орондоо ороод хэвтэж байхад ийшээгээ харахаар сүлжээ нь уначихдаг, ийшээгээ харахад зүгээр болчихдог. Гадаа байхад баахан юм ирээд зүгээр байдаг хэрнээ, байшин дотроо 2 давхарынхаа цаана нь оччихоор байхгүй болчихлог Гэхлээ ямар вел ганаж байна вэ гэхээр кино ч юм vv



"Өөрийн ашигладаг олон сувгийн үйлчилгээний сэтгэл ханамжийг 1-10 хооронд үнэлнэ үү. Яагаад? Сэтгэл ханамжид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дурдана уу?"

Эерэгээр нөлөөлж буй хүчин зүйлс

ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 94%

ХЭРЭГЛЭЭНД ХАНГАЛТТАЙ 13

Хэрэглээний түвшинд ТВ гаралт сайн Асуудал гардаггүй

СУВГИЙН СОНГОЛТ Суваг баялаг Олон сувагтай 6	ШИНЭЧЛЭЛ Хурдан шуурхай Давхар USER 4	ҮНЭ Шинэчлэл 3
ҮЙЛЧИЛГЭЭ Хурдан шуурхай Давхар USER 4	КИНО Сонголт ихтэй НВО 3	ХУРД 2
	ТӨХӨӨРӨМЖ Төхөөрөмж 2	НӨХӨЖ ҮЗЭХ Нөхөж үз... 1

Тайлбар(Эерэгээр нөлөөлж буй хүчин зүйлс) ▾

- Өөрийнхөө хэрэглээний түвшинд бол. Үзье гэж бодоход байж л байдаг. Тэгээд бас олон суваг байгаа болохоор LookTv, Skygo, Voo, Ori бүгдийг нь ашигладаг болохоор надад асуудал тулгардаггүй юм аа. сая нөгөө update хийгээд. Надад бол улам гоё болсон юм шиг санагдсан. Өмнөх нь бол үнэхээр хэцүү байсан. Өмнөхийг нь хуучин хүмүүс сайн ашигладаг юм шиг байналээ.
- Үзье гэсэн юмнуудаа хангалттай үзчихдэг болохоор.
- эерэг нь олон сувгууд гардаг.
- суваг баялаг их дажгүй
- миний хувьд бол Юнивишн-д бол 7 өгнө. Олон сувагтай, олон кинотой. Сувагны, киноны сонголт сайтай.
- Яагаад гэвэл кино сан их, би Скаймедиа-тай айлд очиж үзсэн, байнга шинэчлэж байдаг. Хүмүүс бол гомдоллож л байдаг юм. Өшөө илүү амар болоод байгаа юм уу, бүтээгдхүүн хөгжүүлэлт тал нь бол гайгүй байдаг.
- Юнивишнгийн операторуудтай нь харилцахаар IPTV нь гагцхид байхгүй юу Юнивишн чинь. Тэгээд л за ингээд бүх аргыг нь хэрэглээд л нөгөө гацаа нь гарахгүй байдаг байхгүй юу. Тэгээд л оператор руу нь залгахаар аягүй хурдан таны төхөөрөмж ийм байгаа юм байна. Та ингээд анх удаа энэ төхөөрөмжийг ийм жил болчихсон юм байна. Та одоо манай энийг нэг ингээд солиод үз гээд л тэ. Тэгэнгүүтээ би одоо ингээд өчнөөн жил хэрэглэчихсэн байгаа байхгүй юу Юнивишнг. Тэгэнгүүт л та одоо ингээд 10 хэдэн жил манайхыг ашиглаж байгаа учраас энэ төхөөрөмж уул нь ийм үнэтэй. Та манай үнэнч хэрэглэгч учраас ингэж хөнгөлж өгье ч гэдэг юм уу тэгдэг. Ер нь Юнивишнд бол аягүй их байдаг юм байна лээ. Одоо ингээд төхөөрөмжүүд гацаад эхлэнгүүт л аягүй хурдан шуурхай, би одоо ингээд 4 жоохон хүүхэдтэй гээд л хэлэх юм болвол (тэд нар чинь нөгөө зурагтгүй болвол үхэх гээд байгаа байхгүй юу) тэгэнгүүт аягүй хурдан ирээд л нөгөө асуудлаа аягүй үзрэн шийлүүлдэг. Юнивишнгийн чанар бас аягүй таалагдаал


1 - 32 / 32 < >



"Өөрийн ашигладаг олон сувгийн үйлчилгээний сэтгэл ханамжийг 1-10 хооронд үнэлнэ үү. Яагаад? Сэтгэл ханамжид эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг дурдана уу?"

Сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс

ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 94%



Тайлбар(Сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс) ▾

1. Үзэхгүй суваг ихтэй. Видео сан руугаа орохоор жоохон асуудалтай. Огц буцдаггүй нь сул тал. Сүүлд нэг суваг дээр л ухарч болоод байсан одоо бүр болохгүй байна лээ. Ойлгомжтой биш. Манай эмээ ашиглахаар огт ашиглаж чадахгүй зөвхөн сувгаа нэмэж хасдаг. Эмээ Youtube сайн үздэг. Бусад үйлчилгээ нарын учрыг олж чаддаггүй.
2. шалтгаан ижилхээн бага зэрэг гацаад байдаг төлбөр өндөр учраас
3. төхөөрөмж хуучирхаар сольдог хоцрогдол ажиглагдаад байгаа энийг шинэчлэх гэхээр л мөнгө нэхдэг
4. ер нь бороо орхоор гацдаг контент муу
5. гэхдээ кино сонголт муу 10 кино ээлжлээд гараад байдаг
6. Яагаад гэхээр сарын хугацаа нь дуусахаар телевизийн бүх сувгуудаа хаачихдаг. Тэр дээр жоохон гайхаад байдаг. Угаасаа олон жил хэрэглэж байгаа юм чинь тэр сувгуудыг үлдээгээд байж яагаад болдоггүй юм болоо гэж боддог.
